



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 3 дугаар сарын 6

Дугаар 01

Улаанбаатар хот

I ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2023 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 15.00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 79.3 хувийн ирцтэй хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
С.Чинзориг*

2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлын талаар

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Х.Болорчулуун*

3. Мал, амьтны гоц халдварт өвчний нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

*Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Алтансүх*

4. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын онцгой комиссын гишүүн, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү нарт:

1.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа дуусгавар болсон, халдварын тархалт намжмал байдалд орсон тул Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын “Шар түвшин”-д шилжүүлэх тухай” 01 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, “Ногоон түвшин”-д шилжүүлэх;

Хоёр. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн, Б.Бат-Эрдэнэ, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын урьдчилсан мэдээллээр 3, 4 дүгээр сард агаарын температур нийт нутгаар олон жилийн дунджаас дулаан, 3 дугаар сард баруун болон говийн аймгуудын нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас хүйтэн, бусад хугацаанд бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байх тул болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, Улсын онцгой комиссын 2023 оны “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах;

2.2. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулж үерийн эрсдэл бүхий газруудад айл өрх суурьшихгүй байхыг анхааруулах, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийг нүүлгэн шилжүүлэх;

2.3. Тээврийн хэрэгслийн жолооч, малчид, иргэдэд гүүр, гарамгүй газраар гол, мөрөн гатлахгүй байх, анхаарал болгоомжтой зорчих талаар анхааруулга, сэрэмжлүүлэг тогтмол хүргэх, мөсөн дээгүүр зорчихгүй байх, тээвэр хийхийг хориглох;

Гурав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтансүх нарт:

3.1. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний тархалтыг зогсоох зорилгоор “Мал, амьтны гоц халдварт өвчний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрах, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтансүх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Мал, амьтны сэг зэмийг устгах, ариутгах, болзошгүй халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудын оролцоотой зохих журмын дагуу зохион байгуулж, биелэлт, үр дүнг тухай бүр тооцож ажиллах;

Тав. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

5.1. Отор нүүдлээр нутаг буцаж буй малчдын эрүүл мэнд, малын өвчний үзлэг хийх, гоц халдварт өвчний голомт бүхий нутгаас гаргахгүй байх, малын гоц халдварт өвчний голомтод хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэхдээ Зооноз өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвүүдтэй хамтран ажиллах;

5.2. Цаашид өвөлжилтийн бэлтгэлийг хавраас эхлэх, ногоон тэжээл тариалах малчин өрх, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, ногоон тэжээлийн үрийн захиалгаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 3 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүүд даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

